

УЛСЫН ШАЛГАЛТ - 2025

МОНГОЛ ХЭЛ

XII АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Амжилт хүсье.

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН 12 ДУГААР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ
“А” ХУВИЛБАР **80 МИНУТ**

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР: Сонгох даалгавар бүр 2 оноотой.

БОРЦ

Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг. Үүдний амбаарт өлгөсөн борцноос хоёр годгорыг авч цүнхлээд хичээлдээ явдаг байлаа. Сургууль орох замдаа зажилсаар идэж дуусгана. Заримдаа “танай борц амттай, манайх амттай” гэлцээд сургууль орох замдаа ангийнхаа хөвгүүдтэй холио солио наймаа хийнэ. Хөгшчүүл “түүхий борц идээд цагаан хорхойтой болно доо” гэж анхааруулах ч үл тооно. Тэгээд хэлсэн ёсоор нь цагаан хорхойтно. Хичээлд олон цагаар суух л жаахан хэцүү. Суудал дээрээ хавчигнахийг үзүүлнэ дээ. Харин орой нь нүдэж нунтагласан борцтой гурилтай шөл голдуу хийсэн байх. Хар тагшиндаа дүүргэж аваад бор ходоодоо божийлгоно. Өглөө нь борц хөвүүлсэн будаатай цайны үнэрээр сэрнэ. Өлбөрч өлсөж үзээгүй өссөн гэлээ ч борц гэдэг хатсан бор махны амт хүүхэд насны гэгээн бодол дурсамжийн нэгээхэн хэсэг болж хадгалагджээ. Эмээ минь дээлийнхээ хормой дээр борц жижиглээд тогоотой усанд хийж, самарна. Удалгүй гэр дүүрэн ер бусын гойд сайхан хоолны үнэр ханхална.

Хэдийгээр он цагийг нь бүрэн тогтоож одоо хүртэл чадаагүй ч өвлийн эхээр махаа борцлоод хаврын уртад хүнсэндээ хэрэглэдэг Монголчуудын энэ уламжлалт арга ухаан даруй 3000 жилийн түүхэнд тэмдэглэгджээ. Эртний Хятадын түүхийн сурвалж бичигт талын нүүдэлчид хүнсэндээ хатаасан мах хэрэглэдэг тухай бичсэн байдаг гэнэ лээ. Өвөө, өвөөгийн өвөө, бүр элэнц хуланцын үеэсээ бид махаа борцолж ирсэн байх нь. Одоо ч махаа борцолсоор л байна. Магадгүй ирээдүйд ч борцолно. Үл тасрах өв уламжлал, арга ухаан гэдэг нь ёстой энэ буюу. Энэ л урь идүүлж хатаасан махны талаар үнэн худал нь мэдэгдэхгүй олон янзын сонин хачин зүйл уншиж, сонсож явлаа.

Монголчуудын талаарх “Хятадын эртний нэгэн түүхэн бичигт” тэдний хатааж ууталсан махыг олбоос хүнсэндээ хэрэглэж болно. Гэвч хоолондоо чимхийн төдий хийвээс зохилтой. Нэгэн удаа манай цэргүүд тэр махыг олж хэтрүүлэн хэрэглээд олноор гэдэс мушгирч үхэв” хэмээн бичсэн байдаг тухай эрдэмт ахаасаа сонсож байв. Мөн Хубилай хааны усан флот Япон тэнгист сүйрээд олон жилийн дараа уснаас гаргаж авсан жижиг арьсан богцны доторхийг шинжилбээс борц мах хадгалж байсан нь тогтоогдсон гэдэг юм. Тэгээд ч бидний дээдэс зөвхөн үхэр, тэмээ, ямааны махаа борцолж аян дайндаа авч явдаг байсангүй. Хойлогны мах хүртэл борцолж хатаагаад холын замдаа авч яваад харь дайсны мэсний шарх олсон үедээ идэж, хэдхэн өдөрт тэнхрэн босдог байжээ. Энэ тухай бүр Чингис хаан зарлиг болсон мэдээ баримт ч бий гэнэлээ. “Махыг жижиг жижиг нарийн зүсэж, нар, салхинд өлгөн хатаах ба тийнхүү давсгүй хатаасан мах нь ямар ч үнэр танаргүй сайхан борц болно” гэж тэртээ 13-р зуунд шашин дэлгэрүүлэх нэрээр явсан, тагнуулч лам Гильом де Рубрук “Дорно этгээдэд зорчсон минь” номондоо тэмдэглэсэн байдаг юм. Ном ч юу байхав дээ, тагнуулын тайлан мэдээндээ шүү дээ. Ийм л эртнээс хийж хэрэглэж, биднийхээ хоол хүнсэнд бүрэн дасан зохицсон махан хүнсээ одоо цагт хор мэтээр өөлөн бичигчдэд өс санадаггүй ч ер би дургүй хүн. Тэгж ярих юм бол бид мэт байтугай биднээс хол явж, нэр олсон зүйл маань борц.

Дунд сургуулийн багш минь нүд нь гялалзаж ирээд л “Монгол хүн сансарт ниссэн явдал бол гайхамшиг. Сансарын нисэгч маань огторгуйн уудамд борцоо аваад явсан юм. Одоо ч сансарын нисэгчид хүнсэндээ борц хэрэглэдэг” гэхэд тэр үед үнэхээр бишрэмээр санагдаж, нарийн бүдүүн гэдсэндээ борцны цагаан хорхойтой ч түүнийгээ мартан баясан хөөрдөг байлаа. Хожим Ж.Гүррагчаа баатрын нэгэн өгүүллийг уншаад сансарт ниссэн борц махаараа үнэн бахархаж билээ.

Гурван сая биднээс цас мөсний орон өмнөд туйлд тийм ч олон хүн очоогүй. Миний мэдэхээр цаг уурын инженер Ж.Цэрэндэлэг гуай л тэнд очиж ажиллаж, амьдарч байхдаа олон улсын эрдэм шинжилгээний багийнхандаа борцтой шөлөө хийж өгөөд, өнөөдүүл нь амт шимтийг нь шагшин магтаж гадны тэр олон судлаачид Монголчууд биднийг бишрэн хүндэлсэн гэдэг...

Харин намайг залууд ах дүүс, амраг садан “борц шиг бор юм” гэдэг байлаа. Бодвол харваас туранхай хар юм явсан болохоор тэгж дуудах. Одоо ч тарган цагаан юм алга. Тэгээд ч Я.Цэвэл абугайн монгол хэлний тольд энэ үгийг “урь идүүлж хатаасан мах, - хатингар туранхай” гэсэн үндсэн болон шилжсэн утгаар тайлбарласан байдаг юм. Хэдэн жилийн өмнө олон улсын зохиолчдын сургалтад гурван сар суухаар харь орныг зорив. Аяны богцондоо хэдэн гозгор борц гялгар уутанд хийгээд ёроолд нь нуув. Хил гаалийн газарт нэг муу тарвага шиг тагтгар шар нохой шинжилсээр байгаад нуусан борцыг минь олж, цүнх савыг минь эзэд нь хайр найргүй зад татаад хураагаад авчихаж билээ. Арай л алаг нүдний нулимс асгараагүй. Хүний газар хүнсээ хураалгах ямар олиг байх вэ дээ? Тэр газар хэдэн сар суухад ууттай хэдэн гозгор борц минь л бодогдсоор байж билээ. Хүний нутаг, гүний хошууд тэгэхээр бид эх орон, эцэг эхээсээ дутахгүй муу борцоо их санадаг л байж таарах нь. Монгол хүний мөн чанар гэвэл арай л дэндүүлсэн болох тул энэ хүрээд зогсов.

Өглөө эртээ босоод өвлийн эхээр л говийн нар салхинд хатаасан ямааны борцоо хугалаад будаатай цайндаа хийж үйв. Үнэр нь гэр дүүрээд л сэтгэлд өг сайхан байлаа. Үнэндээ хуршсан мах идээд ходоод гэдэсний хэцүү нэрт өвчин тусаад үхдэг байсан ч борцноосоо л би лав буцахгүй.

П.Батхуяг

1. Эсээг ямар аргаар эхлүүлсэн бэ?
 - A. Харилцан яриа
 - B. Эшлэл
 - C. Болсон явдал
 - D. Дүгнэлт
2. “Борц” эсээний бүтцийг зөв тодорхойлоорой. /эхлэл өгүүлбэрээр зааглав/ /2 оноо/
 - A. Эхлэл: Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг
Гол: Үүдний амбаарт өлгөсөн борцноос хоёр годгорыг авч цүнхлээд хичээлдээ явдаг байлаа.
Төгсгөл: Гурван сая биднээс цас мөсний орон өмнөд туйлд тийм ч олон хүн очоогүй.
 - B. Эхлэл: Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг
Гол: Хэдийгээр он цагийг нь бүрэн тогтоож одоо хүртэл чадаагүй ч өвлийн эхээр махаа борцлоод хаврын уртад хүнсэндээ хэрэглэдэг Монголчуудын энэ уламжлалт арга ухаан даруй 3000 жилийн түүхэнд тэмдэглэгджээ.
Төгсгөл: Монгол хүний мөн чанар гэвэл арай л дэндүүлсэн болох тул энэ хүрээд зогсов.
 - C. Эхлэл: Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг
Гол: Монголчуудын талаарх Хятадын эртний нэгэн түүхэн бичигт” тэдний хатааж ууталсан махыг олбоос хүнсэндээ хэрэглэж болно.
Төгсгөл: Өглөө эртээ босоод өвлийн эхээр л говийн нар салхинд хатаасан ямааны борцоо хугалаад будаатай цайндаа хийж үйв.
 - D. Эхлэл: Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг
Гол: Хэдийгээр он цагийг нь бүрэн тогтоож одоо хүртэл чадаагүй ч өвлийн эхээр махаа борцлоод хаврын уртад хүнсэндээ хэрэглэдэг Монголчуудын энэ уламжлалт арга ухаан даруй 3000 жилийн түүхэнд тэмдэглэгджээ.
Төгсгөл: Өглөө эртээ босоод өвлийн эхээр л говийн нар салхинд хатаасан ямааны борцоо хугалаад будаатай цайндаа хийж үйв.
3. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг олоорой. /2 оноо/
 - A. Өвөө, өвөөгийн өвөө, бүр элэнц хуланцын үеэсээ бид махаа борцолж ирсэн байх нь. Одоо ч махаа борцолсоор л байна. Магадгүй ирээдүйд ч борцолно. Үл тасрах өв уламжлал, арга ухаан гэдэг нь ёстой энэ буюу.
 - B. Өлбөрч өлсөж үзээгүй өссөн гэлээ ч борц гэдэг хатсан бор махны амт хүүхэд насны гэгээн бодол дурсамжийн нэгээхэн хэсэг болж хадгалагджээ.
 - C. Монголчуудын талаарх Хятадын эртний нэгэн түүхэн бичигт” тэдний хатааж ууталсан махыг олбоос хүнсэндээ хэрэглэж болно. Гэвч хоолондоо чимхийн төдий хийвээс зохилтой.
 - D. Миний мэдэхээр цаг уурын инженер Ж.Цэрэндэлэг гуай л тэнд очиж ажиллаж, амьдарч байхдаа олон улсын эрдэм шинжилгээний багийнхандаа борцтой шөлөө хийж өгөөд, өнөөдүүл нь амт шимтийг нь шагшин магтаж гадны тэр олон судлаачид Монголчууд биднийг бишрэн хүндэлсэн гэдэг...
4. “Энэ л урь идүүлж хатаасан махны талаар үнэн худал нь мэдэгдэхгүй олон янзын сонин хачин зүйл уншиж, сонсож явлаа.” өгүүлбэрийн тодруулсан бүтээврийн баймж утгыг тодорхойлоорой. /2 оноо/
 - A. Адилтгах утга
 - B. Онцлох утга
 - C. Барагцаалах утга
 - D. Батлах утга
5. Эсээний дэмжигч мэдээлэл буюу нотолгоог агуулсан хэсэг аль нь вэ? /2 оноо/
 - A. Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг.
B. Ном ч юу байхав дээ, тагнуулын тайлан мэдээндээ шүү дээ.
 - C. Эртний Хятадын түүхийн сурвалж бичигт талын нүүдэлчид хүнсэндээ хатаасан мах хэрэглэдэг тухай бичсэн байдаг гэнэ лээ.
 - D. Гурван сая биднээс цас мөсний орон өмнөд туйлд тийм ч олон хүн очоогүй.

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

2.1. Харин намайг залууд ах дүүс, амраг садан “борц шиг бор юм” гэдэг байлаа. Хэмээх өгүүлбэрийн дүрслэлийн учрыг баримтад тулгуурлан 40-50 үгэнд багтаан дүгнэж бичээрэй. /5 оноо/

2.2 Дараах эхийг уншиж, кирилл бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/



2.3 Эсээний бүтэц, өнгө аяс, сэдэв, агуулгын харьцааг оновчтой гаргаж, дүр дүрслэл, баримт мэдээллийг зохистой ашиглан, гаргацтай, найруулга, зөв бичих дүрмийн алдаагүй, 250-280 үгэнд багтаан “**Цагаан идээний ач тус**” сэдвээр ятган итгүүлж бичих. /20 оноо/

УЛСЫН ШАЛГАЛТ - 2025

МОНГОЛ ХЭЛ

XII АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги:Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Амжилт хүсье.

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН 12 ДУГААР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

“В” ХУВИЛБАР

ХУГАЦАА 80 МИНУТ

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР: Сонгох даалгавар бүр 2 оноотой.

ҮНЭН

Худал гэдэг ойлголт үнэн гэдэг ойлголтыг бий болгодог гэж бид боддог. Ямар нэгэн худал зүйл худал гэдэг нь батлагдах тусмаа тэр нэгэн зүйлээс ангид үнэн гэдэг зүйл байгааг баталдаг гэж бид итгэдэг. Бидний эдэлж хэрэглэж, үзэж харж байгаа дөрвөлжин юмс бүхэн өнцөгтэй. Энэ нь дөрвөлжин юмс бүхэн өнцөгтэй гэсэн ойлголтыг бидэнд өгдөг. Тийм ч гэж бид боддог.

Гэтэл нийтийн тооллын өмнөх тавдугаар зууны үеийн хятадын философич Лаоз “Аугаа их дөрвөлжин өнцөггүй” хэмээн айлджээ. Үүнийг дуулсан хүнд эргэлзэл төрнө. Аль нь үнэн юм бэ хэмээн бодно. Дунд сургуульд “Зэрэгцээ хоёр шулуун хэзээ ч огтлолцохгүй” гэж заадаг. Гэтэл арван наймдугаар зууны оросын математикч Николай Лабочевский “Зэрэгцээ хоёр шулууныг огторгуйн орон зайд хязгааргүй үргэлжлүүлбэл огтлолцоно.” хэмээн баталжээ. Үүнийг дуулсан хүн мөн л эргэлзэж, мөн л аль нь үнэн юм хэмээн бодно. Хэрвээ огтлолцдог гэж үзсэн бол төмөр зам гэдэг тээврийн хэрэгслийг хүн яагаад ч бүтээхгүй байх байсан. Хэрвээ огтлолцдоггүй гэж үзэх юм бол огтлолцсоныг нь гарцаагүй баталсан математикчийн баталгааг яах вэ.

Эндээс ер нь үнэн гэж юу юм гэсэн асуулт хар аяндаа гарч ирнэ. Энэ асуултанд арван есдүгээр зууны германы философич Фридрих Ницше ийм нэгэн философи хариултыг өгсөн байдаг. Тэрээр “Шулуун бүхэн худал, үнэн гэдэг бол муруй. “Цаг хугацаа өөрөө тойрог” хэмээн “Заратустра тэгж хэлсэн юм” зохиолдоо бичсэн байдаг юм. Ницше үнэн гэж юу болохыг тодорхойлоод зогсоогүй Лаоз, Лабочевскийн гаргалгаа үнэн болохыг баталсан юм. Ямар ч дөрвөлжин орчлонгийн хязгааргүй орон зайд хязгааргүй томсгож гэмээн өнцөггүй болно.

Зэрэгцээ хоёр шулууныг огторгуйн орон зайд хязгааргүй үргэлжлүүлж гэмээн хоорондоо огтлолцоно. Энэ чинь юу гэсэн үг вэ гэвэл дөрвөлжингийн өнцөг муруйссаар муруйссаар огтлолцоно гэсэн үг. Эцсийн эцэст хоёулаа муруй болно. Муруй гэдэг үнэн.

Энэ чинь юу гэсэн үг вэ. Шулуун гэж байхгүй. Бидний шулуун гэж үзээд байгаа маань аугаа их муруйн өчүүхэн хэсэг. Ницшегийн “Үнэн гэдэг бол муруй” хэмээх гаргалгааг 20 дугаар зууны эрдэмтэн Альберт Эйнштейн харьцангуйн онолоороо баталж бидний ямагт цэх шулуунаар тархдаг гэж боддог гэрлийг муруй замаар тархдагийг нээсэн юм. Энэ чинь юу гэсэн үг вэ гэвэл орчлонд шулуун гэж байхгүй зөвхөн муруй л гэж бий. Бидний шулуун гэж үзээд байгаа маань агуу их муруйн өчүүхэн хэсэг гэдгийг л баталж буй хэрэг бөгөөд энэ нотолгоо нь Ницшегийн “Үнэн гэдэг муруй” гэснийг батлаад зогсохгүй, шулуун гэж байхгүй, бүгд муруй гэдгийг давхар давхар баталж байгаа юм. Худал гэж байхгүй бол буй бүхэн үнэн болно. Буй бүхэн үнэн бол худал гэж бидний үзэж байгаа бүхэн оронгоо олж хэлбэржин тогтоогүй үнэн. Нэгэнт худал гэж хэлбэржин тогтоогүй үнэн юм бол үнэн гэж юу вэ гэсэн асуулт дахиад гараад ирнэ. Яагаад гэвэл худал гэдэг ойлголтоор үнэн гэдэг ойлголтыг тодорхойлох боломж байхгүй. Тэгвэл үнэн гэж юу вэ?

Үнэн гэдэг бол бүх юмс үзэгдэл нэгэн толинд туссан мэт харагдах зүйл. Өөрөөр бол буй бүхний төгс чанар бол үнэн. Шулуун бүхний муруй нь шулуун бүхэнд байгаа төстэй шинж чанар. Энэ шинж чанар бол гараг эрхсийн бөмбөрцөг хэлбэрт бүтэцтэй төстэй байгаа төс. Энэ бол буй бүхний язгуур нь нэг буюу адил гэсэн үг юм. Эндээс үнэн гэдэг бол буй бүхний язгуур төрхийг хэлнэ гэсэн гаргалгаанд өөрийн эрхгүй хүрэх болно. Үнэн гэдэг буй бүхний язгуур төрх юм. /Д.Батбаяр/

1. Эсээг ямар аргаар эхлүүлсэн бэ?
 - А. Гол санаагаа дэлгэрүүлэх баримтаар
 - В. Илэрхийлэх гэж буй гол санааныхаа ерөнхий мэдээллээр
 - С. Товч түүх, хэрэг явдлаар
 - Д. Эргэцүүлэн бодох асуултаар
2. “Үнэн” эсээний бүтцийг зөв тодорхойлоорой. /эхлэл өгүүлбэрээр зааглав/ /2 оноо/
 - А. Эхлэл: Худал гэдэг ойлголт үнэн гэдэг ойлголтыг бий болгодог гэж бид боддог.

Гол: Гэтэл нийтийн тооллын өмнөх тавдугаар зууны үеийн хятадын философич Лаоз “Аугаа их дөрвөлжин өнцөггүй” хэмээн айлджээ.

Төгсгөл: Үнэн гэдэг бол бүх юмс үзэгдэл нэгэн толинд туссан мэт харагдах зүйл.

В. Эхлэл: Худал гэдэг ойлголт үнэн гэдэг ойлголтыг бий болгодог гэж бид боддог.

Гол: Эндээс ер нь үнэн гэж юу юм гэсэн асуулт хар аяндаа гарч ирнэ.

Төгсгөл: Зэрэгцээ хоёр шулууныг огторгуйн орон зайд хязгааргүй үргэлжлүүлж гэмээн хоорондоо огтлолцоно.

С. Эхлэл: Худал гэдэг ойлголт үнэн гэдэг ойлголтыг бий болгодог гэж бид боддог.

Гол: Зэрэгцээ хоёр шулууныг огторгуйн орон зайд хязгааргүй үргэлжлүүлж гэмээн хоорондоо огтлолцоно.

Төгсгөл: Энэ чинь юу гэсэн үг вэ. Шулуун гэж байхгүй.

Д. Эхлэл: Худал гэдэг ойлголт үнэн гэдэг ойлголтыг бий болгодог гэж бид боддог.

Гол: Энэ чинь юу гэсэн үг вэ. Шулуун гэж байхгүй.

Төгсгөл: Үнэн гэдэг бол бүх юмс үзэгдэл нэгэн толинд туссан мэт харагдах зүйл.

3. Эхийн хөтөч санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг олоорой. /2 оноо/

А. Шулуун бүхний муруй нь шулуун бүхэнд байгаа төстэй шинж чанар.

В. Үнэн гэдэг бол бүх юмс үзэгдэл нэгэн толинд туссан мэт харагдах зүйл.

С. Эндээс ер нь үнэн гэж юу юм гэсэн асуулт хар аяндаа гарч ирнэ.

Д. Энэ шинж чанар бол гараг эрхсийн бөмбөрцөг хэлбэрт бүтэцтэй төстэй байгаа төс.

4. “Үүнийг дуулсан хүн мөн л эргэлзэж, мөн л аль нь үнэн юм хэмээн бодно.” өгүүлбэрийн тодруулсан бүтээврийн баймж утгыг тодорхойлоорой. /2 оноо/

А. Тааварлан барагцаалах утга

В. Төсөөлөн барагцаалах утга

С. Жишин адилтгах утга

Д. Онцлон ялгах утга

5. Эсээний дэмжигч мэдээлэл буюу нотолгоог агуулсан хэсэг аль нь вэ? /2 оноо/

А. Гэтэл нийтийн тооллын..... муруй замаар тархдагийг нээсэн юм.

В. Зэрэгцээ хоёр шулууныг огторгуйн орон зайд хязгааргүй үргэлжлүүлж гэмээн хоорондоо огтлолцоно. Энэ чинь юу гэсэн үг вэ гэвэл дөрвөлжингийн өнцөг муруйссаар муруйссаар огтлолцоно гэсэн үг. Эцсийн эцэст хоёулаа муруй болно. Муруй гэдэг үнэн.

С. Бидний шулуун гэж үзээд байгаа маань..... Тэгвэл үнэн гэж юу вэ?

Д. Худал гэдэг ойлголт..... Тийм ч гэж бид боддог.

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

2.1. “Эндээс ер нь **үнэн гэж юу юм** гэсэн асуулт хар аяндаа гарч ирнэ..” Өгүүлбэрийн тодруулсан хэсгийг баримтад тулгуурлан 40-50 үгэнд багтаан тайлбарлан бичээрэй. /5 оноо/

.....

.....

.....

.....

.....

2.2. Дараах эхийг уншиж, кирилл бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

2.3. Эсээний бүтэц, өнгө аяс, сэдэв, агуулгын харьцааг оновчтой гаргаж, дүр дүрслэл, баримт мэдээллийг зохистой ашиглан, гаргацтай, найруулга, зөв бичих дүрмийн алдаагүй, 250-280 үгэнд багтаан **“Нөхөрлөлийн үнэ цэн”** сэдвээр ятган итгүүлж бичих. /20 оноо/

[illegible]

